

## **2021 оны 1-р сарын 29-ний байдлаар СУРГУУЛЬ БА СУРГУУЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ**

(Боловсрол, залуучууд ба спортын яамны вэб сайтаас авсан мэдээлэл. Боловсрол, залуучууд ба спортын яам нь өөрчлөлтүүдийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ба вэб сайтаар: [www.msmt.cz](http://www.msmt.cz) дамжуулан зарлаж байна).

### ***Боловсролын салбарт зориулсан хямралын арга хэмжээнүүд:***

- Амьсгалын эрхтнийг (хамар, ам) хамгаалах хэрэгслүүд нь зөвхөн амны хаалт төдийгүй гэвч амны маск, алчуур, ороолт эсвэл дусал тархахаас сэргийлдэг бусад хэрэгслүүд нь болдог гэж үздэг - цаашид зөвхөн "амны хаалт" гэж нэрлэдэг.
- Хэрэв сургуулийн захирал нь сургуулийн ажилтанд эсвэл сурагчдад ковид-19 өвчний илрэлийн талаар мэдээлэл авбал, Мужийн эрүүл ахуйн станцын ажилтантай холбоо барина.

### **Цэцэрлэгүүд**

- Цэцэрлэгүүд нь эрүүл ахуйн дүрмийг баримтлаж үйл ажиллагаа явуулж болно.
- Хүүхэд ба сурган хүмүүжүүлэх ажилтнууд нь амны хаалтыг зүүх үүрэггүй.
- Сургуулийн байранд гуравдагч этгээд нь зөвхөн амны хаалттай орж болно, тэгэхдээ зөвхөн зайлшгүй шаардлагатай тохиолдолд байранд орж болно.

### **Бага сургууль**

- **Бүрэн цагийн сургалт** нь бэлтгэл ангид, 1-р ба 2-р ангид болон жижиг гэгддэг сургуульд явагддаг.
- Сурагчид болон сургуулийн ажилтнууд нь сургуульд байх бүх хугацаандаа амны хаалтыг зүүх ёстой.
- Бүрэн цагийн сургалт нь нэгэн төрлийн бүлэгт явагдана (*ангийн бүлгүүд нэгдэхгүй буюу огт холилдохгүй*). Сурагчдын сургуульд ирэх, очих ба шилжих хөдөлгөөнийг зохицуулахдаа төрөл бүрийн ангийн сурагчдыг өөр хооронд нь уулзахгүйгээр зохион байгуулдаг.
- Бүрэн цагийн сурагчид нь хичээлийн бус цагийн бүлгэмд ба сургуулийн клубт очих боломжтой.
- Боловсролын үеэр дуу дуулах, спортоор хичээллэхийг хориглоно.
- **Бусад сурагчид нь алсын зайн сургалтанд оролцох үүрэгтэй.**
- Энэ сургуулийн жилд дөрвөн жилийн сургалтын чиглэлтэй сургуульд чех хэл, уран зохиол ба математикийн **элсэлтийн нэгдсэн шалгалтуудыг** өгөх шаардлагагүй. Хэрэв сургуулийн захирал нь элсэлтийн нэгдсэн шалгалт өгөхгүй гэж шийдвэл, сургууль дээр сургуулийн элсэлтийн үйл ажиллагаа заавал явагдах ёстой. Сургуулийн вэб сайтыг үргэлж үзэх шаардлагатай байдаг.
- **CSF програм** нь элсэлтийн шалгалтын бэлтгэл ажлыг хангахад туслах болно (5, 7 ба 9-р ангийн сурагчид).

### **Сургууль дээрхи хооллох боломж**

- **Сургуулийн гуанз нээлттэй боловч, зөвхөн бүрэн цагийн сургалтын сурагчдыг үйлчилнэ.** Бусад сурагчид нь хуваарилах цонхоор хоол хүнс авах боломжтой.
- Алсын зайн сургалтын үеийн сурагчид хөнгөлөлттэй үнээр өдрийн хоолд хамрагдах эрхтэй.
- Сурагчид ба сургуулийн ажилтнууд нь сургуулийн гуанзанд хооллохоос бусад тохиолдолд амны хаалтыг зүүх үүрэгтэй.

### **Дунд сургууль**

#### **Ерөнхий боловсролын дунд сургууль ба консерваторт алсын зайн сургалт явуулагдана.**

- Элсэлтийн шалгалт, эцсийн шалгалт, төгсөлтийн шалгалт, абсолютори/мэргэжлийн төгсөлтийн болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгалтуудыг өгөх боломжтой. Дүрмүүд нь холбогдох шалгалт ба одоогийн хямралын арга хэмжээний журмын дагуу зохицуулагддаг.

- **Төгсөлтийн шалгалт** дээр энэ жилд найруулгын ажил бичихгүй бөгөөд хэл ба математикийн шалгалтанд дидактик тест хийх хугацааг уртасгана. Аман шалгалтыг бүгдээрээ заавал өгөх ёстой. Сургуулийн профайл/мэргэжлийн хэсгийн шалгалт өгөх үед захирлууд нь тухайн сургуулийн нөхцөл байдлын дагуу шалгалтын хэлбэрийг зохицуулдаг. Тийм учраас тухайн сургуулийн вэб сайтыг үргэлж үзэж байх шаардлагатай. Хямралын ерөнхий арга хэмжээний талаарх сүүлийн үеийн мэдээллийг MŠMT вэб сайтаас авах боломжтой.

- ČŠI програм нь одоо төгсөлтийн шалгалтанд бэлтгэл хийхэд туслах болно.

Чех Улсын Үндэсний сурган хүмүүжүүлэх хүрээлэнд /NPI ČR/ бэлтгэсэн, 2021 оны 1-р сарын 29-ний өдөрт.